



Глоб Интернэшнл  
ТББ

## "ХҮНИЙ ЭРХИЙН МЭДЭЭЛМЭЭР ДАМЖУУЛАН ИРГЭНИЙГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БЭЛТГЭВ



Их Британий  
ЭСЯ

Глоб Интернэшнл ТББ, Монголын ТББ-ын форум

# САНАЛ

## ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООСОН ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬЧЛАН ЗОХИЦУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэр буюу захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр нь эрх бүхий этгээдээс хуулиар тусгайлсан эрх олгосон тохиолдолд л гаргадаг, эрх олгож, үүрэг хүлээлгэсэн, тухайн салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд заавал биелүүлэхийг шаарддаг, эрх зүйн үр дагавар бүхий баримт бичиг юм. 2009 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн судалгаагаар тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан 391 хуулиас 188 буюу нийт хуулийн 50 орчим хувьд нь "дүрэм", "журам", "заавар", "загвар", "аргачлал", "стандарт", "жагсаалт", "нормчлол", "төлөвлөгөө", "хөтөлбөр" батлуулахаар зохицуулсан байна. Батлан гаргах субъектийн хувьд УИХ, УИХ-аас байгуулагддаг байгууллага, Засгийн газар, ИТХ, түүний тэргүүлэгчид, төрийн захиргааны төв байгууллага, тухайн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн засаг дарга болон бусад субъектүүд болох зөвлөл, хороо, комисс зэрэг өргөн хүрээг хамардаг. Эндээс дүгнэхэд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах эрхийг олон төрлийн субьектэд, түгээмлээр олгож байгаа нь харагдаж байгаа юм.

Монгол Улсын Засгийн газар сүүлийн жилүүдэд нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэрийг цэгцлэх, шийдвэр гаргах зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр олон чухал санал санаачлага гаргасныг тэмдэглэх нь зүйтэй. 2010 оны Засгийн газрын 119-р тогтоолоор "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам" баталсан явдал нь энэ салбарт гарсан нэг дэвшил билээ. Энэхүү журмаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахаас эхлэн хүчин төгөлдөр болох хүртэлх бүх үе шатны зохицуулалтыг боловсронгуй болгох, хэм хэмжээ тогтоосон шийдвэрт тавих хяналтыг сайжруулах, субьектийн хүрээг өргөжүүлэх зэрэг олон дэвшилтэт зохицуулалтыг тусгаж өгсөн. Үүний дүнд зохицуулалтын чанар үр нөлөө дээшлэх, албан тушаалтнууд дур зоргоор авирлах явдлыг таслан зогсоох боломжийг бий болгосон.

Гэсэн хэдий ч энэхүү тогтоол нь зөвхөн Засгийн газрын харъяа байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрт л үйлчилж байгаа юм. УИХ, УИХ-аас байгуулагддаг байгууллага, Засгийн газар, ИТХ, түүний тэргүүлэгчид зэрэг олон тооны субьектүүдийн батлан гаргаж буй захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр нэгдсэн хяналтын гадуур байсаар байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 1-р бүлгийн 1-р зүйлд "...хууль дээдлэх..." нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн хэмээн тунхагласан. Энэхүү зарчмыг мөрдлөг болгох үүднээс хуулийг дагаж гарч байгаа хэм хэмжээ тогтоосон шийдвэр нь Үндсэн хууль, хууль тогтоомжид нийцсэн байх учиртай. Үүний тулд хуулиар тусгайлан эрх олгогдсон хүрээнд гарч буй бүх шийдвэрийг нэгдсэн хяналтад байлгах нь дээрх зарчмыг хэрэгжүүлэх гол арга зам билээ. Мөн одоогийн зохицуулалтын түвшинд буруутай албан тушаалтантай хариуцлага тооцох боломжгүй.

Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт тавьж буй өнөөгийн хяналтын тогтолцоо нь нэгдмэл биш, тодорхой хүрээгээр хязгаарлагдсан, буруутай албан тушаалтантай хариуцлага тооцох боломжгүй байгаа зэрэг нь хуулиас давсан зохицуулалт гарах, хүний эрх, эрх чөлөөг хууль бусаар хязгаарлах, зөрчих, шударга бус өрсөлдөөнийг хөхиүлэх, хүнд суртал, бичиг цаасны зардлыг нэмэгдүүлэх зэрэг олон сөрөг үр дагаврыг дагуулж байна. Энэ нь цаашлаад эдийн засгийн хөгжлийн хурдыг сааруулж, авлигыг өөгшүүлж, хувийн хэвшлийг албан бус сектор руу түлхэхэд хүргэдэг. Тиймээс захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг бүхэлд нь хянах тогтолцоо, үйл явцыг зохицуулсан хуулийг нэн даруй батлан гаргах шаардлагатай байна. Нөгөө талаас хуульчлан зохицуулах асуудал нь УИХ-ын 1998 оны 18-р тогтоолоор батлагдсан Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 38-д тусгагдсан бөгөөд энэ нь эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийх ажлын нэг юм.